

УДК 82-131

DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-68-77

**Жангар тууль дахь зарим үг хэллэгийн
харьцуулсан судалгаа
(Халимаг Монгол хөрвүүлгийн жишээ дээр)
(= Сопоставительное исследование некоторых
оборотов речи в эпосе «Джангар» (на примере
калмыцкого и монгольского переводов))**

*Бямбаахүү Нанжид*¹

¹ МУБИС, Багшийн сургууль, Монгол хэл – нийгмийн ухааны тэнхим
Pedagogical College at the Mongolian State Pedagogical University, Ulan
Bator, Mongolia

E-mail: www.nanjaa11@gmail.com

© КалмНЦ РАН, 2020

© Бямбаахүү Нанжид, 2020

Хураангуй. Халимаг Жангарыг монгол хэлнээ хөрвүүлэх ажлыг академич Ц. Дамдинсүрэний удирдлагаар профессор Т. Дүгэрсүрэн 1940 онд Б. Басанговын хэвлүүлсэн 12 бүлэг жангараас хийж гүйцэтгэжээ. Улмаар 2000 онд 1978, 1990 онуудад Москвад хэвлэгдсэн халимаг “Жангар”-ын 26 бүлгийн сонгомол эхийг орчин цагийн монгол хэлэнд хэвлэсэн байдаг. Дээрх хоёр хөрвүүлгийг уг эхтэй нь тулгаж зарим үг хэллэгт тайлбар хийсэн болно.

Түлхүүр үг: Жангар тууль, хэл-аялгуу, нэр томъёо

Аннотация. Публикация на монгольском языке 12 глав калмыцкого «Джангара», подготовленного к изданию в 1940 г. Б. Басанговым, осуществлена профессором Т. Дугэрсурэн под руководством академика Ц. Дамдинсүрэна. Затем в 2000 г. на современном монгольском языке были опубликованы тексты 26 песен «Джангара», изданных в г. Москве в 1978 и 1990 гг. В статье дан сравнительный анализ некоторых диалектных слов двух вышеуказанных монгольских изданий и калмыцкого оригинала.

Ключевые слова: эпос «Джангар», диалекты языка, понятия и термины

Благодарность. Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Бямбаахүү Нанжид. Жангар тууль дахь зарим үг хэллэгийн харьцуулсан судалгаа (Халимаг Монгол хөрвүүлгийн жишээ дээр) Сопоставленное исследование некоторых оборотов речи в эпосе «Джангар» (на примере калмыцкого и монгольского переводов) // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2020. № 2. С. 68–77. DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-68-77

UDC 82-131

DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-68-77

Comparative study of some turns of phrase in the epos “Jangar” (on the example of Kalmyk and Mongolian translations)

*Nanjid Byambaakhuu*¹

¹ Pedagogical College at the Mongolian State Pedagogical University, Ulan Bator, Mongolia

E-mail: www.nanjaa11@gmail.com

© KalmSC RAS, 2020

© Nanjid Byambaakhuu, 2020

Abstract. The twelve chapters of Kalmyk epos «Jangar» which were edited for publication by B. Basangov in 1940 were published in Mongolian by T. Dugersuren under the supervision of Ts. Damdinsuren. Later, twenty six songs from «Jangar» published in Moscow in 1978 and 1990, were published in modern Mongolian in 2000. The article gives a comparative analysis of some dialect words from the two mentioned above Mongolian publications and the original text in Kalmyk.

Keywords: epos «Jangar», language dialects, notions and terms

Acknowledgement. The article was presented at the international scientific online conference «Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects — II», held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Nanjid Byambaakhuu. Comparative study of some turns of phrase in the epos «Jangar» (on the example of Kalmyk and Mongolian translations). *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS*. 2020. No. 2. Pp. 68–77. DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-68-77

Монгол угсаатан аман зохиолын арвин баялаг сан хөмрөгтэй ард түмэн билээ. Түүний дотор өөрийн гэсэн өндөр суурийг эзлэн заларсан «Жангар» хэмээх нэгэн эрдэнэсийн уул байх бөгөөд эдүгээгийн цаг үед туульд өгүүлсний нэгэн адил «Алдар ноён богд Жангар» гэх нэрээ их холд цуурайтуулан олон газрын эрдэмтэд анхаарал хандуулан судалсаар даруй 200 гаруй жилийн нүүрийг үзэж байна.

Халимаг Жангарыг монгол хэлнээ хөрвүүлэх ажлыг академич Ц. Дамдинсүрэний удирдлагаар профессор Т. Дүгэрсүрэн 1940 онд Б. Басанговын хэвлүүлсэн 12 бүлэг «Жангар»-ыг халх аялгуунд буулган 1963 онд «Жангар» гэдэг нэрээр крилл үсгээр хэвлүүлжээ [Катуу 2013: 16]. Мөн академич Ц. Дамдинсүрэн «Жангар» туулийн 550 жилийн ойг тохиолдуулан 1963 онд хэвлэгдсэн дээрх эхийн дөрвөн бүлгийг нэмж засварлан шүлэглэсэн эх бэлтгэснийг шавь Р. Отгонбаатар нь 1998 онд хэвлүүлсэн байна [Катуу 2013: 17]. Мөн профессор Т. Дүгэрсүрэн 1978, 1990 онуудад Москвад хэвлэгдсэн халимаг «Жангар»-ын 26 бүлгийн сонгомол эхийн 26 бүлгийг баримтлан бүрэн эхээр нь Монгол хэлээр хөрвүүлэн буулгасныг 2000 онд хэвлүүлсэн эхийн оршилд эрхлэн хөрвүүлэгч «Жангар» туулийн хувилбар тус бүрийн үг хэллэгийг нарийвчлан судлах нь нийт монголчуудын хэл, аялгуу, авиазүй, үгзүй, өгүүлбэрзүй, үгсийн сангийн судалгаанд чухал ач холбогдолтой төдийгүй, бас нэр томьёо, толь бичиг зохиох, орчуулга хийх, болон утга зохиолын хэлийг баяжуулах зэрэгт ч биет ач тустай» [Дүгэрсүрэн 2000: 5] гэж өгүүлснийг баримтлан бид 1963 хөрвүүлсэн «Жангар» [Дүгэрсүрэн 1963], «Жангар» 26 бүлэг

сонгомол эх [Дүгэрсүрэн 2000] тэргүүтнийг 1940 онд хэвлэгдсэн Б. Басанговын «Джанъгър»-ийн 12 бүлэг, оршил хэсэгтэй харьцуулан зарим үг хэллэгийг нягтлах зорилгоор харьцуулан ажиглалт хийж үзлээ. Дээрх судалгааг гүйцэтгэхийн тулд ойлголтын зөрүүтэй буусан үг хэллэгийг түүвэрлэн эрдэмтэн Б. Х. Тодаевын «Я изучаю “Жангар”, «Калмыцко-русский словарь», Халимаг-орос хэлний толь бичгүүд, Монгол хэлний хураангуй, дэлгэрэнгүй тайлбар толь бичиг, орос монгол толь бичгүүдийг ашиглан харьцуулж ажилласан болно. Энэхүү судалгаандаа «Жангар» туулийн эхний долоон бүлэг, оршил магтаалыг дээрх байдлаар харьцуулан үзвэл оршил магтаалд: арм, бумблв, хүүхэд гэсэн үг, хэллэгийг харьцуулан үзэх шаардлага тулгарч байна. Үзвэл:

Аранзал зээрдийнхээ хурдан цагт

Алтан шар цоохор армынхаа (илдийнхээ) хурц цагт

[Дүгэрсүрэн 1963: 12]

гэсэн бол “Жангар”-ын сонгомол эхэд:

Аранзал зээрдийнхээ хурдан цагт

Алтан шар цоохор жадныхаа хурц цагт [Дүгэрсүрэн 2000: 268]

хэмээн шууд засаж найруулан бичсэн байна. Эхний хувилбарт арам-арм гэсэн үгийг илд хэмээн буулгасан бол сүүлийн хувилбарт “жад” хэмээн засаж найруулсан байна. Мөн хэсэгт:

... шатар болсон бумбалива (өргөө) нь өөрөө боссон

Шарын дөрвөн төрөө гар дээрээ авсан [Дүгэрсүрэн 1963: 12]

гэсэн бол сонгомол 26 бүлэгтэй хувилбарт:

...Шатар болсон бумба нь өөрөө боссон

Шарын дөрвөн төрөө гар дээрээ авсан [Дүгэрсүрэн 2000: 268] хэмээн “бумбалива” хэмээн бичсэн анхны хувилбарыг засч «бумба» болгон бичсэн байна. Харин Б. Басанговын хувилбарт дээрх үгийг «...Шатр болсон бумблвнь» хэмээн бичсэн бол Б. Х. Тодаевийн «Хальмг орс толь»-д [Тодаева 2009: 62] «бумблв — дворец» (орд өргөө) хэмээн тайлбарласан бол, халимаг-орос хэлний толь

бичигт «бумблв-дворец, мавзолей», монгол хэлний тайлбар тольд [Баярсайхан 2009: 105] «бумба-бунхан», «бумбалбай — байшин барилга, орд харш» хэмээн тайлбарласан боловч 1966 онд хэвлэгдсэн Я. Цэвэлийн «Монгол хэлний товч тайлбар толь»-д дээрх үг байхгүй боловч 2000 оноос хойно хэвлэгдсэн толиудад байгаагаас үзвэл дээрх үг нь «Жангар» туулийн хөрвүүлэгтэй холбогдон сүүлд нэмэгдсэн бололтой байна. Иймд бид харьцуулан үзээд «бумблв» гэсэн энэ үгийг «суварга» гэж хөрвүүлэх хувилбар гаргаж байна. Харин судлаач Ж. Лувсандорж «Жангарт гарч байгаа бумбын орон, бумбын шашны ёсны учраар «Жангар»-т магтан дуулсан бумбын орны нэрийг тайлбарлууштай [XXII 2011: 151] гэсэн байдаг.

Мөн «Жангар» туулийн оршил бүлгийн төгсгөл хэсэгт таарах хүүхэд (*күүкд-калм*) хэмээх үгийн хувилбаруудыг авч үзвэл:

...Цуутай цагаан бэрүүд нэг дугуйраа гүйцээд

Цусан улаан хүүхэд нэг дугуйраа гүйцээд [Дүгэрсүрэн 1963: 17]

...Цуутай цагаан бэрчүүл нэг дугуйраа гүйцээд

Цусан улаан хүүхэд нэг дугуйраа гүйцээд [Дүгэрсүрэн 2000: 273]

хэмээн хоёр хувилбарт адил буулгасан байна. Тэгвэл «Жангар» туулийн бусад хувилбаруудад энэхүү «күүкд» гэсэн хэллэг:

Хүснэгт 1. Утгын харьцуулал

түвин дөрвн хаань күүкд холад	отверг он дочерей четырёх ханов континента
түрэ бийнь арвн миңһн күүкд күн ниилүлгсн	голенище его сапога расшито руками десяти тысяч женщин
эр барсин зүрктэ, күүкд бүргд шүүрлһтэ	с сердцем барса, с ухваткой самки беркута

Гэх мэтчилэн хүүхэд бус хүүхнүүд буюу «күүкн» (хүүхэн) гэсэн үгийн олон тоог зааж байгаа. Харин Монгол хэлний тайлбар толиудад [Баярсайхан 2009] хүүхэд — бага насны хөвгүүд охид хэмээн буулгасныг үзэхэд, найрт нэг дугуйраа гүйцээд сууж байгаа хүүхэд бус «хүүхнүүд» хэмээн буулгах нь зүй хэрэг юм.

Үүнээс гадна бүлэг бүрт тохиолдож байгаа «Хаш мөнгөн үүд» хэмээх хэллэгийн тухайд «хаш» хэмээгч нь өнгө бүр гоёл чимэглэлд хэрэглэх нэгэн зүйл эрдэнийн чулуу [Цэвэл 1966: 672] хэмээн тайлбарласан бөгөөд Б. Басанговын халимаг хэлний эхэд «... Бээшнъгин хашр мөнъгн үүднд Хээртэ Джанъгъран авад ирв» [Басангов 1960: 13] хэмээн хаш бус «хашр» гэж тэмдэглэсэн бөгөөд туулийн дотор 42 удаа таарч байна. Тодаевын толь [Тодаева 2009]-д «хашр» — сплошной (үргэлжилсэн цулгуй, үрглж-калм), цельный (бүхэл, цул, хольцоогүй), хэмээн тайлбарласан бөгөөд утгачилбал «цул мөнгөн үүд» «хатуу мөнгөн үүд» гэсэн утгаар хөрвүүлэх нь зүйтэй болж таарч байна.

Үүнээс гадна «Хонгорын гэр авлагын бүлэгт “...Не йовгсн йовлан Номин йовдлар күцэхэд”» [Басангов 1960: 29] гэсэн хэсгийг «Нэг явсан явдлаа Номын ёсоор гүйцээгээд» [Дүгэрсүрэн 1963: 32], «За! Явсан үйлээ Номын ёсоор гүйцээгээд» [Дүгэрсүрэн 2000: 353]. Энэ хоёр хувилбарыг нятлан үзвэл «За» гэж буулгасан сүүлийн хувилбар зөв болж таарч байна. Гэтэл МОНСУДАР-аас 2014 онд гаргасан «Тууль» хэмээх ном-д «...Нэг явсан явдлаа номын ёсоор гүйцээгээд» [Сүлд-Эрдэнэ-нар 2014: 102] хэмээн хуучин 1963 оны хувилбарыг шууд хуулбарлан хэвлэсэн байна. Мөн энэ бүлэгт гарах «Арчм дүнгэ өргн болад» [Басангов 1960: 43] гэсэн хэллэгийг үзвэл «...Алд хэрийн өргөн» [Дүгэрсүрэн 1963: 43], «...Дэлэм өргөн» [Т. Дүгэрсүрэн 2000: 365], «...Алд хэрийн өргөн болоод» [Сүлд-Эрдэнэ-нар 2014: 107] гэх мэтээр буулгасан байх бөгөөд толь бичгээс үзвэл арчм-аршин (хагас алд) [Тодаева 2009: 28] гэж буулган тайлбарласаныг үзвэл «...Дэлэм өргөн» гэж буулгасан хувилбар нь зүйд нийцэж байна. Учир юу гэвэл энэхүү туульд «алд» гэх үг мөн хэлбэрээ (салхинаас алд хурдан, бумбын наян найман алд сүүлээ хаяад гм)тавин удаа тааралдаж байна. Гэтэл эл туульд «дэлэм-калм» гэх хэллэг (санаанаас дэлэм хурдан гм) зургаан удаа тохиолдож бүгд өөрийн үндсэн утгаар хэлэгдсэн байна. Харин монгол хэлний хураангуй тайлбар тольд «арчим» гэсэн үг тохиох бөгөөд энэхүү үг нь «0.711мм-тэй дүйх уртын хэмжээ» [Баярсайхан 2009: 40] хэмээн тэмдэглэснээс үзвэл «арчм» гэх энэ хуучирсан хэллэг нь алд ч бус дэлэм ч бус маш бага хэмжээний

дүрслэл ажээ. Энэ бүлэгт «... Таниг ийм төр болдж гидж Сангсн угав» [Басангов 1960: 32], «...— Гертэсн кү көөгэд бээдг Ямр төр авсн авсн күмбч» хэмээх хэсэгт «төр болох, төр авах» гэсэн хоёр үг байх бөгөөд монгол хэлэнд «... Таныг ийм төр болж гэж санасангүй, ... Гэрээсээ хүн хөөгөөд байдаг Ямар төр авсан хүн бэ чи?» [Дүгэрсүрэн 1963: 34, 35], «...Таныг ийм суудал эзэлсэн гэж Санасангүй би, ... Гэрээсээ хүн хөөгөөд байдаг Ямар төрийн суудал эзэлсэн хүн бэ чи?» [Дүгэрсүрэн 2000: 356, 357] хэмээн «төр», «төрийн суудал», «ийм суудал» гэх мэтээр буулгасан байна. Тэгвэл энэ үгийн үндсэн утгыг авч үзвэл «төр» гэх үг нь үндсэн хоёр утгаар орсон ба туульд гучин нэгэн удаа тохиолдож байна. Монгол хэлний тайлбар толиудад улс төр, төр ёс гэх мэт утгуудыг тэмдэглэсэн байна. Харин халимаг орос хэлний тольд төр ёс, улс төр гэсэн утгаас гадна *болхах кергтэ төр (это дело такое, что надо быть осторожным), күнд төр (трудный вопрос), номин туск төр (научная проблема) төр уга*, гэх мэт утгыг тайлбарласан бөгөөд эрдэмтэн Б. Х. Тодаевийн тольд «төр-право» [Тодаева 2009: 266] үүнээс үзвэл «төр» гэх энэ үгийг «учир, зүйл, асуудал, ёс» гэх мэт утгуудаар илэрхийлэх нь зүйд нийцэж байна. Мөн энэ бүлэгт «...— Аав, хойр миньгын хөөтэ күн Цахрт бээдж болш уга» [Басангов 1960: 54], «...Ааваа хоёр мянган хоньтой хүн Цахирт байж болшгүй» [Дүгэрсүрэн 1963: 54], “...Аав! хоёр мянган хоньтой хүн Отогт байж болохгүй нь” [Дүгэрсүрэн, Жангар, 2000: 374] эндээс үзвэл цахр гэсэн энэ үг «цахир»(хатуу цагаан чулуу), «отог» (засаг захиргааны нэгж) гэсэн хоёр хэлбэрээр буусан байна. Энэ хоёр хэлбэрээс Отог гэсэн хэлбэрийг зөвшөөрч болох боловч Монгол хэлний хураангуй тайлбар толь дахь «цахар (хуучирсан) буюу хаад ноёдын орд харшийг тойрон суусан зарц айлууд» [Баярсайхан 2009: 932] гэсэн нь «цахр – поселение бедняков, окружающее дворцы князей» [Тодаева 2009: 334] гэсэнтэй тохирч байгааг үндэс болгон «Цахар» гэж буулгах нь зүйтэй гэж үзэж байна.

Тэгвэл «Буурал халзан морьтой Булингарын хөвүүн догшин хар Саналын бүлэгт «...Эл болад бээхлэ, тэвн джилэ татлгъя, Миньгын нег джилэ алв, өгч, Оруд нутг болх аминь авч ирич» [Басангов 1960: 64], «...Ээлтэй болоод байвал таван жилийн татвар,

Мянга нэг жилийн алба өгч, оруул нутаг болох амы нь авч ирээч» [Дүгэрсүрэн 1963: 59], «...Ээлтэй байя гэвэл Тавин жилийн татвар, Мянга нэг жилийн алба өгч Хараат нутаг болох амы нь авч ирээч» [Дүгэрсүрэн 2000: 383] хэмээн «Оруул нутаг», хараат нутаг хэмээн хоёр янзаар буулгасныг харгалзан монгол хэлний тайлбар толиудыг үндэслэн үзвэл «орууд-байлдан дагуулж эзэлсэн нутаг» [Баярсайхан 2009: 492], «хараат- хараат эрхшээлд байгаа, ямар нэгэн улсын эрхшээлд орших» [Цэвэл 1966: 662] гэж тайлбарласан байгааг харгалзан «хараат» эсвэл «орууд» гэж буулгах нь зөвтэй байна. «Оруул» гэсэн хэллэгийн хувьд утга дүйх тайлбар байхгүй байна. Харин 1963 оны хувилбарт «таван жилийн татвар» гэж буулгаснаа засаж «тавин жилийн татвар» гэж буулгажээ. Мөн энэ бүлэгт «... эгрэд одхнь Нээмн чимгн бишв» [Басангов 1960: 65], хэмээх хэллэгийг «...Хугараад одох нь Найман чөмөг биш үү» [Дүгэрсүрэн 1963: 60], «...Хувхайраад одох нь Найман чөмөг л» [Дүгэрсүрэн 2000: 382] гэж хоёр янзаар буулгасан байна. Үүнийг нягтлан үзвэл «Äгр зандн», «эгрх», «эгрэх», «эгрэчкэд» гэх мэт дөрөв таван хувилал байна. Монгол хэлний тайлбар тольд «агирам, агируу, агирах» гэх мэт утга байх бөгөөд 1. хатуу, 2. хөлдүү гэх мэт утга илтгэж байна. Халимаг-Орос хэлний тольд мөн 1. увядший – гандсан, буурсан, поблекший — сульдсан, 2. засохший (сухой)- хатах, хувхайрах гэх мэт утга илэрхийлж байна. Үүнээс үзэхэд аль ч хувилбарт «хугарах» тухай утга заахгүй харин хатах хувхайрах утга зааж байгаа нь илт байна. Тэгвэл, эгрэд одхнь Нээмн чимгн (хувхайрах найман чөмөг) үүнээс гадна эгр зандн жидин үзүр үзгдв (тэмдэг нэрийн утгаар «Хатуу зандан»), эгр хар булгин көвэд (хагсуу хар булгийн хөвөөнд), ааһ цусан асхлцнав гив, хэр һазрт оч арһсн, түлэнэ күн болж заргдхин орчд, эгр хар булгин көвэд ааһ цусан асхлцнав, гэх мэт утгаар орсон байна. Үүнээс гадна «... Таньгъл билгиннь таслад, Тавн ухагъинь тарагъад» [Басангов 1960: 77] «...Таньгъд билгн билгнь тасрад, тавн ухаан тарад» [Басангов 1960: 116], «...Тансаг билгий нь таслаад, Таван ухааны нь тараагаад» [Дүгэрсүрэн 1963: 69], «...Таалал билиг нь тасраад, таван ухаан нь сарниад» [Дүгэрсүрэн 1963: 96], «... Танхил билиг нь тасраад, Таван ухаан нь тасраад» [Дүгэрсүрэн 2000: 393], гэх

мэтээр тансаг билэг, таалал билэг гэх мэтээр буулгасан байна. Туулийг нягтлан үзвэл таалал (таалл чини болв, тав деерчн гарв-калм), тансаг (таньсг Хонһр минь-калм) гэх мэт үндсэн утгаараа таарч байгаа учир үүнийг дахин нягтлан үзэх шаардлагатай болж байна.

Арслангийн араг улаан Хонгор, араг манзын бууралтай, айх догшин Магнай хаантай байлдсан бүлэгт «Арслньгин арг улан Хоньгъриг Түүгэрчн аху кехшв» [Басангов 1960:97] гэх хэллэг байх бөгөөд «...түүгээр чинь ахлаач болгохгүй би» [Дүгэрсүрэн 2000:Дүгэрсүрэн 1963: 81], «...түүгээр нь гэр орныхоо ажиллагч хийхгүй би» [Дүгэрсүрэн 2000: 289] гэж ажиллагч, ахлаач гэсэн хоёр янзаар буусан байгааг тодруулбал «аху» нь ажиллагч мөн боловч «аргал түлээний хүн» гэж буулгавал илүү зохимжтой байна.

Түүний дараагийн бүлэгт « ...— Би түрүлдж замин талагъур одсв — ...эврэнь заман гемшэв» [Басангов 1960: 131] гэж гарах бөгөөд энэ үгийг шууд утгаар нь «...би түрүүлж замын талаар одсугай, ... өөрийнхөө тогоочийг зэмлэв» [Дүгэрсүрэн 1963: 108], «...би түрүүлж зам талруу очъё гэв. ...өөрийнхөө зам тогоочоо шийтгэв» [Дүгэрсүрэн 2000: 424] гэж хоёр янзаар буулгасан бөгөөд «зам» гэдэг нь тогоочийг нэрлэж байгаа хуучирсан үг бөгөөд дээрх хоёр хэсэгт «зам харгуй», «зам-тогооч» гэсэн аль аль утгаар нь орсон бөгөөд хоёуланд тогооч гэсэн утгаар буулгах нь зүйтэй юм.

Дүгнэн үзвэл «Жангар» туулийг орчин цагийн монгол хэлэнд буулгасан нь үнэлж баршгүй гавьяат үйлс мөн боловч үг хэллэг, түүний хөрвүүлэгт анхааран бичих шаардлагатай юм. Сайтар ухварлан үзвэл уг туульд гарч буй үг хэллэг бүгд манай монгол хэлний нутгийн аялгууны үгтэй утга дүйх тал ажиглагдаж байгааг мөн тодотгох хэрэгтэй. Мөн цаг нэгэн цагийг бодвол уг туулийн үг хэллэгийг харьцуулан үзэх нөхцөл боломж бүрдэж байгаа бөгөөд цаашид халимаг хэлнээс торгууд аялгад хэрхэн буусан болохыг нятлан үзэж нэгтгэн дүгнэх шаардлагатай юм. Үүнээс гадна монгол туургатны аман зохиолын нэгэн оргил болсон Жангар туулийн үг хэллэгийг алдаа мадаггүй буулгаж гэмээн уншигч олон хийгээд хожмын судлаачдад үнэт хэрэглэгдэхүүн болно гэж үзэж байна.

Ном зүй

- XXII 2011 – Жангар тууль судлал. Улаанбаатар: Соёмбо, 2011. 169 с.
- Басангов 1960 – Жангар. Героический эпос калмыцкого народа. М.:
Издательство восточной литературы, 1960. 362 с.
- Баярсайхан 2009 – Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг.
Улаанбаатар: Монсудар, 2009.
- Дүгэрсүрэн 1963 – Жангар. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1963.
- Дүгэрсүрэн 2000 – Жангар. Улаанбаатар: Полиграф, 2000. 704 х.
- Катуу 2013 – Монгол туульсийн судалгаа (Vol. I). Улаанбаатар: Соёмбо
принтинг, 2013.
- Сүлд-Эрдэнэ-нар 2014 – Тууль. Улаанбаатар: Адмон, 2014.
- Тодаева 2009 – Я изучаю «Жангар». Элиста: Герел, 2009. 397 с.
- Цэвэл 1966 – Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар: Улсын
хэвлэлийн хороо, 1966. 912 с.